Нийт зардлын 70.8 хувийг тэтгэврийн, 14.5 хувийг эрүүл мэндийн, 5.8 хувийг ҮОМШӨ-ний, 6.7 хувийг тэтгэмжийн, 2.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 3 дугаар сард 146.7 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ 138.3 тэрбум төгрөгт хүрчээ.


Олгосон нийт тэтгэврийн 75.0 хувийг өндөр насны, 10.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.4 хувийг тэжээгчээ алдсаны, 11.5 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



**ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ**

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2016 оны 3 дугаар сарын эцэст 13119 болж, өмнөх оны мөн үеэс 5.3 хувь буюу 741 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 6775 буюу 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 25. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16.9 хувь буюу 2218 нь 15-24 насны, 39.8 хувь буюу 5217 нь 25-34 насны, 23.2 хувь буюу 3041 нь 35-44 насны, 20.1 хувь буюу 2643 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.9 хувь буюу 2743 нь Чингэлтэй, 15.8 хувь буюу 2075 нь Сүхбаатар, 14.6 хувь буюу 1909 нь Баянзүрх, 12.9 хувь буюу 1691 нь Сонгинохайрхан, 10.5 хувь буюу 1371 нь Хан-Уул, 9.7 хувь буюу 1279 нь Баянгол, 7.9 хувь буюу 1033 нь Налайх, 6.8 хувь буюу 894 нь Багануур, 0.9 хувь буюу 124 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2016 оны 3-р сард ажилгүй 3836 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 947 иргэн ажилд зуучлагдан орж, 3689 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 22. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /4-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
Нийт ажилгүйчүүд	11526	13860	13119	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	4208	5503	4701	36.5	39.7	35.8
Тусгай дунд боловсролтой	1160	1017	917	10.1	7.4	7.0
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	647	739	733	5.6	5.3	5.6
Ерөнхий боловсролтой	5459	6527	6676	47.4	47.1	50.9
Мэргэжилгүй	52	74	92	0.4	0.5	0.7

2016 оны эхний 3 сард 11746 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 6.0 хувь буюу 663 хүнээр өсчээ.

2016 оны эхний 3 сард 2341 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.0 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 8.6 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 89.4 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

2016 оны эхний 3 сард 9780 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 163 хүүхдээр цөөн байна. Нийт төрсөн хүүхдийн 13.5 хувь буюу 1318 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна. Нялхсын эндэгдлийн 33.1 хувь буюу 45 нь Баянзүрх, 23.5 хувь буюу 32 нь Сонгинохайрхан, 14.7 хувь буюу 20 нь Чингэлтэй, 10.3 хувь буюу 14 нь Сүхбаатар, 8.8 хувь буюу 12 нь Баянгол, 5.2 хувь буюу 7 нь Хан-Уул, 2.9 хувь буюу 4 нь Налайх, 1.5 хувь буюу 2 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.


Хүснэгт 23. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 3 сард

	2014 он	2015 он	2016 он	$\frac{2016}{2015}$ %
Амаржсан эхийн тоо	9740	9845	9695	98.5
Амьд төрсөн хүүхэд	9832	9943	9780	98.4
Эхийн эндэгдэл	4	3	1	33.3
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	154	150	178	118.7
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	15.66	15.09	18.20	120.6

Нялхсын эндэгдлийн 22.5 хувь буюу 40 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 3.11 промилээр өсчээ.

Нийслэлд 2016 оны эхний 3 сард 13246 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.8 дахин буюу 8542 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 64.33 промилээр тус тус өсчээ.

Зураг 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 58.9 хувийг улаан бурхан, 8.7 хувийг салхин цэцэг, 6.3 хувийг гар хөл амны өвчин, 6.3 хувийг тэмбүү, 4.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.5 хувийг трихомониаз, 4.0 хувийг заг хүйтэн, 2.1 хувийг улаан эсэргэнэ, 2.0 хувийг цусан суулга, 0.7 хувийг вируст хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 24. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 3 сард

	хэмжих нэгж	2015 он	2016 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	4704	13246	8542	2.8 дах
	10000 хүнд	36.44	100.77	64.33	
Вируст гепатит	бодит тоо	146	93	- 53	- 36.3
	10000 хүнд	1.13	0.71	- 0.42	
Цусан суулга	бодит тоо	206	263	57	1.3 дах
	10000 хүнд	1.60	2.00	0.40	
Салхин цэцэг	бодит тоо	929	1151	222	23.9
	10000 хүнд	7.20	8.76	1.56	
Гахай хавдар	бодит тоо	14	59	45	4.2 дах
	10000 хүнд	0.11	0.45	0.34	
Сальмонеллэз	бодит тоо	9	9		
	10000 хүнд	0.07	0.07		
Улаан эсэргэнэ	бодит тоо	54	283	229	5.2 дах
	10000 хүнд	0.42	2.15	1.73	
Улаан бурхан	бодит тоо	69	7808	7739	113.2 дах
	10000 хүнд	0.53	59.40	58.87	
Хоолны хордлого	бодит тоо	12	2	- 10	- 6 дах
	10000 хүнд	0.09	0.02	- 0.07	
Ёлом	бодит тоо	25	28	3	12.0
	10000 хүнд	0.19	0.21	0.02	
Нярайн халдвар	бодит тоо	3		- 3	
	10000 хүнд	0.02		- 0.02	
Гар хөл амны өвчин	бодит тоо	202	840	638	4.2 дах
	10000 хүнд	1.56	6.39	4.83	
Тэмбүү	бодит тоо	1116	835	- 281	- 25.2
	10000 хүнд	8.65	6.35	-2.30	
Заг хүйтэн	бодит тоо	552	531	-21	-3.8
	10000 хүнд	4.28	4.04	0.24	
Трихомониаз	бодит тоо	464	598	134	1.3 дах
	10000 хүнд	3.59	4.55	0.96	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	693	608	- 85	- 12.3
	10000 хүнд	5.37	4.63	- 0.74	
ДОХ	бодит тоо	4	9	5	2.3 дах
	10000 хүнд	0.03	0.07	0.04	




НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ 2016 оны эхний 3 сард Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 3.3 мянган км урттай, 142 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ. Нийтийн тээврийн үйлчилгээнд хөлс төлөлтийг цахим системд шилжүүлж, хотын гудамж, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, чиглэлүүдийн давхцалыг багасгах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээний шинэчилсэн төлөвлөлтийг хэрэгжүүлж байна.



Зураг 27. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 28. Зорчигч тээврийн чиглэлийн урт



2016 оны эхний 3 сард Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг 49 аж ахуйн нэгж эрхлэн явуулсан нь өмнөх оны мөн үеэс 6 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, их багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын тоо 5.3 хувиар, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчлэгч аж ахуйн нэгжийн тоо 11.8 хувиар, такси үйлчилгээ эрхлэгчдийн тоо 17.6 хувиар бүүрчээ.

Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 29. Зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй ААН-ийн тоо



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд 2016 оны эхний 3 сард 170.1 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 48.6 сая хүн тээвэрлэж, 20.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Зорчигчдын тоо өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар буюу 21.6 сая хүнээр, үйлчилгээний орлого 26.4 хувиар буюу 7.2 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Энэ нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Хөлс төлөлтийн цахим хэлбэрт шилжиж, зорчих тасалбар таслахгүйгээр кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлсэнээр зорчигчдын хөлс төлөлтөнд тавих хяналт суларсан.


- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс олгох болсноор үйлчилгээ эрхлэгчдийн хувьд шугамын орлогыг нэмэгдүүлэх, зорчигчдыг суулгах сонирхол буурч, үр ашиг багатай зорчилт хийх болсон.
- Чиглэл маршрутын шинэчилсэн төлөвлөлтийн хүрээнд зүүн гарын эргэлт болон чиглэлийн давхцалыг бууруулах үүднээс зарим чиглэлийг богино эргэлтээр эргүүлэх болж, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор шаардлагатай хэсгийн хүн үрсгалын төвлөрөл, цэгүүдэд зогсоол буудлыг шийдэж өгөөгүйгээс иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих эрэлтийг бүрэн хангаж чадахгүй байгаа нь зорчигчийн тоо болон үйлчилгээний орлого буурахад голлон нөлөөлжээ.

Хүснэгт 25. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2016 оны эхний 3 сард

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Үүнээс:			Зорчигч (сая хүн)	Үүнээс:		
			карт	бэлэн мөнгө	нөхөн олговор		карт	бэлэн мөнгө	нөхөн олговор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	8.7	1.3	2.9	4.5	21.1	3.5	6.3	11.4
Автобус (хувийн)	18	8.5	2.4	3.8	2.3	20.4	6.4	8.3	5.7
Троллейбус (хувийн)	1	2.4	0.02	0.04	2.3	5.9	0.06	0.13	5.7
Бага багтаамжийн автобус	15	0.45	-	0.45	-	1.2	-	1.2	-
Дүн	35	20.0	3.7	7.2	9.1	48.6	9.9	15.9	22.8

Төлбөрийн цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газар нь UB смарт ХХК-тай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, троллейбус, их, дунд багтаамжийн нийт 1250 тээврийн хэрэгсэлд карт унших төхөөрөмжийг суурилуулан, картаар зорчих нөхцлийг ханган ажилласан байна.

Зураг 30. Үндсэн үзүүлэлт, төлбөрийн хэлбэрээр




2016 оны эхний 3 сард бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 18.6 хувийг картын орлого, 35.8 хувийг бэлэн мөнгө, 45.6 хувийг “нөхөн олговор”-ын орлого эзэлж байна.

Нийтийн тээврээр зорчигчдын 20.3 хувь нь картаар үйлчлүүлсэн байхад 32.7 хувь нь бэлэн мөнгө төлж, 47.0 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл, оны эхний 3 сард нийтийн тээврийн хэрэгслээр давхардсан тоогоор 22.8 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 9.1

тэрбум төгрөгийг тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговор хэлбэрээр шилжүүлсэн байна.


Зураг 31. Үндсэн үзүүлэлт, тээврийн төрлөөр




Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт болох тээсэн зорчигч хийгээд үйлчилгээний орлогын зонхилох хэсэг нь их, дунд багтаамжийн автобусны үйлчилгээнд ногдож байна. Тухайлбал, 2016 оны эхний 3 сард нийт зорчигчдын 70.4 хувь нь их, дунд багтаамжийн автобусаар зорчиж, үйлчилгээний нийт орлогын 71.5 хувийг бүрдүүлжээ.

Цахилгаан тээврийн хувьд зорчигчдын 27.4 хувь, тээврийн орлогын 26.5 хувь нь тус тус ногдож байна.

Зураг 32. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 33. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



2016 оны эхний 3 сард нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 26 автобус, 10 такси үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 103 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн 72 автобус, 31 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.


Хүснэгт 26. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2015 оны эхний 3 сар	2016 оны эхний 3 сар
Бүгд		2240	2035
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	250	319
	Хувийн өмч	866	824
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	171	124
	Бүүхиа чиглэл	200	170
Троллейбус	Төрийн	52	41
	Хувийн	8	8
Такси		693	549

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 2035 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 14.4 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 56.2 хувь нь их багтаамжийн автобус, 27.0 хувь нь такси байна.

Шугаманд өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 840 автобус, 16 угсраа автобус, 30 троллейбус, бага багтаамжийн 252 автобус, 549 такси ажиллажээ.

Зураг 34. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 82.3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины

үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Зураг 35. Хүлээлтийн хугацаа, минут




Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацаанд зарим өөрчлөлтүүд гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага багтаамжийн автобусны хүлээлт 5.8 минутаар, цахилгаан тээврийнх 1.9 минутаар тус тус нэмэгдэж, их багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаанд өөрчлөлт гараагүй байна.

2016 оны эхний 3 сард нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 468 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 88.3 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

Зураг 36. НТ-ийн үйлчилгээний талаарх санал, гомдол, жил бүрийн оны эхний 3 сард



Зураг 37. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын барагдуулалт



**ХАРИЛЦАА ХОЛБОО**

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2016 оны эхний 3 сард 165.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар буурчээ. Нийт орлогын 71.3 хувь буюу 118.0 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Нийт орлогын 71.3 хувь буюу 118.0 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна. 2016 оны эхний 3 сард нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 226.2 мянга болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 хувиар нэмэгджээ. Нийт суурин телефон цэгийн 191.5 мянга буюу 84.7 хувийг айл өрх ашиглаж байна. Нийслэлд телефон утас эзэмшигч өрхийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 8.1 хувиар өсчээ. Үүнд гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгчид нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна.


Хүснэгт 27. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2015 оны эхний 3 сар	2016 оны эхний 3 сар
Нийт орлого	сая төг	167756.4	165510.1
Үүнээс: хүн амаас	сая төг	129081.8	118024.5
Суурин телефон цэг	тоо	204926	226227
Үүнээс: айл өрхийн	тоо	177269	191546
Утасгүй телефон	тоо	876	545
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	1822.1	1893.6
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	294111	319216

Зураг 38. Суурин телефон цэгийн тоо



Зураг 39. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2016 оны эхний 3 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.4 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 54.7 хувь буюу 1.9 сая орчим хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 71.5 мянгаар нэмэгджээ.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 315.2 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1578.3 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.5 мянга гаруй болж өмнөх оны мөн үеэс бүүрсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх арга хэмжээ хэрэгжиж байгаатай холбоотой. Нийслэлд 0.6 мянга гаруй хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 40. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн болон Ай Пи телевизийн 18 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн 319.2 мянган хэрэглэгчдэд үйлчилж байна. Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.6 хувийг айл өрх эзэлдэг байна. Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 50-130 гаруй сувгаар үйлчилгээ хүргэж байна.

Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчид 2 аж ахуйн нэгжийн үйлчилгээг 49-50 хүртэл сувгаар хүлээн авчээ. Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-99.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-9900 төгрөгийн тарифтай байв.



**АМЬДАРЧ БУЙ ОРЧИН**

Нийслэлийн агаарын дундаж температур 2016 оны 3-р сард дунджаар -4.7<sup>o</sup>C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.5<sup>o</sup>C-аар дулаан, олон жилийн дундажтай харьцуулбал -7.7<sup>o</sup>C-аар хүйтэн байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 12.7<sup>o</sup>C, үнэмлэхүй бага температур -24.4<sup>o</sup>C, хур тунадасны нийлбэр 10.9 мм, салхины үнэмлэхүй их хурд 20 м/секунд хүрч, цасан шуургатай 1 тохиолдлыг бүртгэжээ.


Хүснэгт 28. Агаарын бохирдолт, мг/м<sup>3</sup>, 3-р сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдолын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.020	257	0.193	177	0.039
Азотын давхар исэл	NO <sub>2</sub>	0.040	293	0.086	99	0.035
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	309	0.368	133	0.100
	PM <sub>2.5</sub>	0.050	174	0.159	106	0.062
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	748	5.134	-	1.000
Озон	O <sub>3</sub>	0.100	692	0.082	-	0.037


\*- Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2016 оны 3-р сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 31 удаа, Баруун 4 зам орчимд 26 удаа, Телевиз орчимд 14 удаа, 32-ын тойрог орчимд 11 удаа, Амгалан орчимд 7 удаа, 1-р хороолол орчимд 4 удаа, Толгойт болон Ургах наран хороолол орчимд тус бүр 3 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Телевиз болон Амгалан орчимд тус бүр 29 удаа, Толгойт болон 32-ын тойрог орчимд тус бүр 28 удаа, 13-р хороолол орчимд 19 удаа, Баруун 4 зам орчимд 18 удаа, 1-р хороолол орчимд 14 удаа, Хархорин зах орчимд 12 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Зураг 41. Хүхэрлэг хийн агууламж, мг/м<sup>3</sup>




Зураг 42. Азотын давхар ислийн агууламж, мг/м<sup>3</sup>




10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог орчимд 28 удаа, Толгойт орчимд 26 удаа, Амгалан орчимд 19 удаа, Баруун 4 зам болон 1-р хороолол орчимд тус бүр 16 удаа, Телевиз орчимд 14 удаа, 13-р хороолол орчимд 10 удаа, Нисэх орчимд 4 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 26 удаа, Телевиз орчимд 22 удаа, Амгалан орчимд 19 удаа, 13-р хороолол орчимд 15 удаа, Баруун 4 зам болон Нисэх орчимд тус бүр 12 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 43. Тоосны /PM<sub>10</sub>/ агууламж, мг/м<sup>3</sup>



Зураг 44. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м<sup>3</sup>



Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2016 оны 3-р сарын 10-ны өдрийн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдлийн хэмжээ хэвийн, хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 56.7 дахин, амоны азот 35.0 дахин, эрдэс фосфор 1.9 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч, Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.



Хүснэгт 29. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 3-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл - Экспо төв	Баруун 4-н зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	-	0.027	0.024	0.031	0.040	0.019	-	0.010	0.055	0.077	0.067
	Хамгийн их	-	0.047	0.059	0.084	0.073	0.035	-	0.018	0.109	0.148	0.193
	XXX* -с давсан хувь	-	69	50	73	90	39	-	-	90	100	97
	Хэмжилтийн тоо	-	26	28	26	31	31	-	25	31	29	30
Азотын давхар Исэл NO <sub>2</sub>	Дундаж	-	0.068	0.024	0.067	0.037	0.019	0.024	0.016	0.027	0.037	0.032
	Хамгийн их	-	0.085	0.052	0.086	0.057	-	0.056	0.026	0.051	0.058	0.059
	XXX* -с давсан хувь	-	100	14	100	36	-	10	-	12	45	23
	Хэмжилтийн тоо	-	26	28	31	31	31	30	28	26	31	31
Нүүрс- төрөгчийн дугуу исэл, CO**	Дундаж	-	1.271	-	0.843	1.097	0.641	0.327	0.599	1.407	1.932	0.884
	Хамгийн их	-	2.925	-	2.725	4.475	1.838	1.600	1.345	4.543	5.134	2.768
	XXX* -с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	83	-	92	29	92	92	85	91	92	92
Тоос PM10	Дундаж	0.055	0.108	0.109	0.085	0.182	0.066	0.046	0.074	0.150	0.105	0.121
	Хамгийн их	0.089	0.183	0.174	0.162	0.368	0.100	0.077	0.135	0.283	0.168	0.267
	XXX* -с давсан хувь	-	62	57	32	90	-	-	15	84	48	63
	Хэмжилтийн тоо	28	26	28	31	31	18	30	27	31	29	30
Тоос PM2.5	Дундаж	-	0.047	-	0.050	-	-	-	0.047	0.096	0.077	0.052
	Хамгийн их	-	0.091	-	0.100	-	-	-	0.070	0.159	0.141	0.093
	XXX* -с давсан хувь	-	46	-	48	-	-	-	44	84	76	63
	Хэмжилтийн тоо	-	26	-	31	-	-	-	27	31	29	30
Озон O <sub>3</sub> **	Дундаж	0.041	-	-	0.026	0.027	-	0.048	0.027	0.037	0.041	0.047
	Хамгийн их	0.073	-	-	0.052	0.063	-	0.082	0.056	0.077	0.080	0.077
	XXX* -с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	87	-	-	87	93	-	92	84	92	67	90

\* - Хүлцэх хэм хэмжээ, \*\* - CO, O<sub>3</sub>-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Офицеруудын ордонгийн орчимд хэмжилт хийгдээгүй

Хүснэгт 30. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 3-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O <sub>2</sub> )	≥6	4.42	хэвийн	0.5	горим алдагдаж онцгой их бохир
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ <sub>5</sub> )	≤ 3	1.6		170.0	56.7 дахин
Нитридийн нэгдэл (NO <sub>2</sub> )	≤ 0.02	0.001		0.018	хэвийн
Амоны азот (NH <sub>4</sub> )	≤0.5	0.02		17.5	35.0 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.005		0.189	1.9 дахин

\*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ

Нийслэлийн хэмжээнд 2016 оны эхний 3 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 39 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 35.9 хувийг газрын зөрчил, 17.9 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 12.8 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 10.3 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 23.1 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 11.3 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Хүснэгт 31. Байгаль орчны зөрчил, төрлөөр, оны эхний 3 сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2015 он			2016 он		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	2	9	0.9	3	1	-
Ан, амьтан	2	3	-	3	1	-
Газрын	6	45	-	3	14	7.7
Ус	1	1	-	-	-	-
Ургамал, хөрсний бохирдол	1	4	-	2	4	0.6
Агаар, химийн хорт бодис	9	9	1.2	3	5	1.7
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	6	6	-	2	7	1.1
Геодези зураг зүй, кадастр	3	3	-	1	-	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	3	2	-	1	-	-
Бусад	1	-	-	12	7	0.2
Бүгд	34	82	2.1	30	39	11.3



### ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2016 оны эхний 3 сард нийслэлийн хүн амд 8.6 сая м<sup>3</sup>, аж ахуйн нэгж, байгууллагад 2.6 сая м<sup>3</sup> цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан нийт усны хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар бүүрсан байна.

Хүснэгт 32. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он III сар	2016 он III сар	$\frac{2016}{2015}$ %
Шахсан ус	мян.м <sup>3</sup>	13172.1	13415.1	101.8
Борлуулсан ус	мян.м <sup>3</sup>	11595.8	11177.6	96.4
Хүн амд	мян.м <sup>3</sup>	8651.2	8621.7	99.7
ААНБ-д	мян.м <sup>3</sup>	2944.6	2555.9	86.8
Татан зайлуулсан бохир	мян.м <sup>3</sup>	11373.9	11170.9	98.2
Хүн амаас	мян.м <sup>3</sup>	8052.1	8299.2	103.1
ААНБ-аас	мян.м <sup>3</sup>	3321.8	2871.7	86.5
Ус борлуулалтын орлого	сая төг	6757.5	6409.6	94.9
Хүн амаас	сая төг	3962.4	3887.3	98.1
ААНБ-аас	сая төг	2795.1	2522.3	90.2
Сувагжуулалтын орлого	сая төг	4086.9	4337.8	106.1
Хүн амаас	сая төг	1790.9	2011.7	112.3
ААНБ-аас	сая төг	2296.0	2326.1	101.3

Нийт борлуулсан усны 79.6 хувийг хүн амд, 20.4 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна. Хүн амд түгээсэн цэвэр усны 96.3 хувь буюу 8.3 сая.м<sup>3</sup> усыг төвлөрсөн шугамаар, 314.1 мян.м<sup>3</sup> усыг ус түгээх байраар, 2.5 мян.м<sup>3</sup> усыг тэврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 13.7 сая.м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 11.2 сая.м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 45. Борлуулсан ус, сараар, мян.м<sup>3</sup>



Зураг 46. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м<sup>3</sup>





### ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2016 оны эхний 3 сард 113 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өссөн байна. Нийт гамшигт хүчтэй цасан шуурга 1, цасны нурангийн 2 тохиолдол, харин хүний үйл ажиллагаатай холбоотой 110 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 6 осол, бусад төрлийн 104 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 4 хүн амь насаа алджээ. Харин 231 хүнийг аварч, гамшгийн үршгийг арилгах ажилд нийт 1.0

тэрбум төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 33. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2015 он	2016 он	2016 он / 2015 он
Бүгд	896	640	71.4
Багануур	8	10	125.0
Багахангай	3	3	100.0
Баянгол	119	102	85.7
Баянзүрх	235	161	68.5
Налайх	26	22	84.6
Сонгинохайрхан	206	139	67.5
Сүхбаатар	109	72	66.1
Хан-Уул	77	54	70.1
Чингэлтэй	113	77	68.1

Нийслэл хотод 2016 оны эхний 3 сард ахуйн 640 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар буурсан байна.

Гал түймрийн улмаас 3 хүн (үүнээс, хүүхэд 1) амь насаа алдаж, 9 хүн (үүнээс, хүүхэд 5) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 73 хүн, 43 мал, амьтан, 336 байшин барилга, 1.3 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.


Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 114, санамсаргүй байдлаас 439, шалтгаан тогтоогдоогүй 41, бусад шалтгаанаар 46 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт 307 гэр, орон сууц, 67 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 53 машин техник, малын 52 хашаа, саравч, бусад төрлийн 161 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 434, төрийн өмчийн 112, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 94 объект өртөж, нийт 1.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 47. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 48. Гал түймэр, байршлаар




Нийслэлийн Онцгой байдлын газраас 2016 оны эхний 3 сард 66 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 66 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 2749 айл өрх, 3683 объектод үзлэг, шалгалт хийж, 17419 галын зөрчил илрүүлж, 35 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 589 заавал биелүүлэх албан шаардлага, 1019 мэдэгдэл хүргүүлж, 16.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



**ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ** 2016 оны эхний 3 сард 4909 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувь буюу 174 хэргээр буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 53.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр дээгүүр байна.

Гэмт хэргийн улмаас 1583 хүн гэмтэж осолдож, 119 хүн нас барж, төр ард иргэдэд 14.8 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 24.0 хувь буюу 3.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 49. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 37.8 хувийг хулгайн, 23.8 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 10.6 хувийг залилан, 6.4 хувийг танхайн, 4.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 34. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 3 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	Тоо	Хувь
Хүний амь	28	21	- 7	- 25
Хүчин	31	31	-	-
Дээрэм	144	112	- 32	- 22.2
Хулгай	1644	1855	211	12.8
Булаалт	59	53	- 6	- 10.2
Залилан	503	521	18	3.6
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	1244	1170	- 74	- 5.9
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	302	222	- 80	- 26.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	121	91	-30	-24.8
Ашиглах	60	58	- 2	- 3.3
Танхайрах	377	315	- 62	- 16.4
Бусад	570	460	- 110	- 19.3
<b>БҮГД</b>	<b>5083</b>	<b>4909</b>	<b>- 174</b>	<b>- 3.4</b>

2016 оны эхний 3 сард 13713 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 6.6 хувь буюу 963 хүнээр буурсан байна.

2016 оны эхний 3 сард хүндэтэр хэрэг 2207, хөнгөн хэрэг 2381, хүнд хэрэг 223 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4-38.1 хувиар буурч, харин онц хүнд хэрэг 98 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсчээ.

Хүснэгт 35. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	Тоо	Хувь
Багануур	82	77	- 5	- 6.1
Багахангай	5	6	1	20.0
Баянгол	810	847	37	4.6
Баянзүрх	1308	1150	- 158	- 12.1
Налайх	130	123	- 7	- 5.4
Сонгинохайрхан	841	822	- 19	- 2.3
Сүхбаатар	896	812	- 84	- 9.4
Чингэлтэй	665	635	- 30	- 4.5
Хан-Уул	346	437	91	26.3
ДҮН	5083	4909	- 174	- 3.4


Хүснэгт 36. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2016 оны эхний 3 сард

дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	26	14	53.8
Багахангай	3	1	33.3
Баянгол	414	270	65.2
Баянзүрх	767	392	51.1
Налайх	32	19	59.4
Сонгинохайрхан	584	370	63.4
Сүхбаатар	593	249	42.0
Чингэлтэй	444	210	47.3
Хан-Уул	218	120	55.0
ДҮН	3081	1645	53.4

Хүснэгт 37. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2015 он	2016 он	2015 он	2016 он
Багануур	15	17	12	15
Багахангай	-	3	-	2
Баянгол	188	238	151	191
Баянзүрх	458	460	383	397
Налайх	24	29	20	26
Сонгинохайрхан	325	353	300	331
Сүхбаатар	330	360	236	301
Чингэлтэй	228	266	187	240
Хан-Уул	76	129	72	116
ДҮН	1644	1855	1361	1619

Зураг 50. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 3360 болж, 2015 оны мөн үеэс 6.6 хувь буюу 236 хүнээр бүүрсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 13.6 хувь буюу 456 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 15.5 хувь буюу 522 нь согтуугаар үйлдсэн, 7.6 хувь буюу 255 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 3.4 хувь буюу 115 нь хүүхэд, 15.8 хувь буюу 532 нь эмэгтэйчүүд байна.



**ХОТ ТОХИЖИЛТ**

2016 оны эхний 3 сард нийслэл хотыг тохижуулах ажилд 8.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Нийтийн эзэмшлийн зам талбайд тээвэрлэх зориулалттай 500 ширхэг хогийн сав шинээр байршуулж 200.7 сая төгрөгийг зарцуулав.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн асалт дунджаар 95.4 хувь, реклам асалт 94.9 хувьтай байлаа. Тохижилтын ажлаар 71.5 мянган м<sup>2</sup> зүлэгжсэн талбай, 49.7 мянган м<sup>2</sup> цэцэрлэгжсэн талбай, 15984 ширхэг мод, 4800 ширхэг сөөгийг арчилж тордон 48.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 38. Тээвэрлэсэн хог, мян.тонн, дүүргээр

Дүүрэг, бусад байгууллагууд	Тээвэрлэсэн хог	хог, бүтцээр					
		Орон сууц	Гэр хороолол	Албан байгууллага	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	2.2	0.9	1.0	0.1	0.1	0.1	-
Багахангай	1.5	0.9	0.5	0.1	-	-	-
Баянгол	29.8	11.1	9.7	5.9	3.1	-	-
Баянзүрх	35.9	5.4	21.6	7.2	0.8	0.9	-
Налайх	2.1	0.5	1.1	0.5	-	-	-
Сонгинохайрхан	39.6	5.4	29.5	3.3	1.4	-	-
Сүхбаатар	16.7	4.6	4.9	5.7	0.1	-	1.4
Хан-Уул	11.1	2.3	4.2	3.8	0.8	-	-
Чингэлтэй	33.9	8.5	15.3	5.1	5.0	-	-
Дүн	172.8	39.6	87.8	31.7	11.3	1.0	1.4

Дарж устгасан хогны 16.0 хувийг орон сууцны хороолол, 46.8 хувийг гэр хороолол, 32.6 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 4.6 хувийг зам талбайн хог эзэлж байна.

Дүүргүүдийн тохижилт үйлчилгээний байгууллагууд 2016 оны эхний 3 сард 16041 золбин нохойг устгаж энэ ажилд 120.3 сая төгрөг зарцуулав.

Хог цэвэрлэгээний ажлаар 18573.2 мянган м<sup>2</sup> зам талбайг цэвэрлэж, 172.8 мянган тонн хог тээвэрлэж, Багануур дүүрэгт 2.3 мянган тонн, Багахангай дүүрэгт 1.4 мянган тонн, Налайх дүүрэгт 1.0 мянган тонн, Нарангийн энгэр, Морин даваа, Цагаан даваанд төвлөрсөн цэгт 206.2 мянган тонн хогийг тус тус дарж устгав.